



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗАР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2025

Тайлан хянасан:

М. Батгэрэл	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал
-------------	--

Н. Түмэн-Өлзий	Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Ph.D)
----------------	--------------------------------------

Тайлан боловсруулсан:

Н. Жаргалсайхан	Хөдөлмөрийн судалгааны секторын эрхлэгч
-----------------	---

М. Ган-Эрдэнэ	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
---------------	----------------------------------

Тайлан зөвлөх:

Б. Алтанцэцэг	Эн ар си си ХХК үндэсний судалгаа зөвлөгөөний төвийн гүйцэтгэх захирал (Ph.D), дэд профессор
---------------	--

Б. Соёлмаа	Ахлах судлаач (Ph.D), дэд профессор
------------	-------------------------------------

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Б. Хос-Эрдэнэ	Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн
---------------	---

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам, 55-р байр 2 давхар 3 тоот Утас: 77111331, 77121286 Вэб хуудас

АГУУЛГА.....	Error! Bookmark not defined.
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
ӨМНӨХ ҮГ	8
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
1.1 Үндэслэл.....	10
1.2 Зорилго, зорилт	10
1.3 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл	11
1.4 Судалгааны арга зүй, зохион байгуулалт	11
БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭЖИХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	13
2.1 Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	13
2.2 Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	14
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД	16
БҮЛЭГ 4. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	21
4.1 Ерөнхий мэдээлэл	21
4.2 Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа	27
4.3 Аж ахуй эрхлэлтийн сургалт	38
БҮЛЭГ 5. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	40
5.1 Ерөнхий мэдээлэл	40
5.2 Сургалтын үйл ажиллагаа	46
БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	54
6.1 Дүгнэлт	54
6.2 Санал зөвлөмж	54

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажил чиг үүргийн хүрээнд тулгардаг хүндрэл бэрхшээл /хувь/	16
Зураг 2. Мэдээлэл түгээж буй байдал /хувь/	16
Зураг 3. Хүсэлт гаргасан иргэдийн бүртгэлийг хадгалж байгаа байдал, байршлаар /хувь/	17
Зураг 4. Санхүүжилтийн квот хүсэлтийн дагуу ирдэг эсэх, байршлаар /хувь/	17
Зураг 5. Санхүүжилт хүсэлтээс бага ирдэг шалтгаан /хувь/	18
Зураг 6 Иргэдийн гомдол, саналыг шийдвэрлэдэг байдал /хувь/	18
Зураг 7. Өмнө нь тухайн арга хэмжээний хамрагдалтыг шалгадаг эсэх /хувь/	18
Зураг 8. Сургалтын хүрээнд ямар нэгэн дэмжлэг үзүүлдэг үү /хувь/	19
Зураг 9. Санхүүгийн дэмжлэгийн хүрээнд ямар хяналт хийдэг вэ /хувь/	19
Зураг 10. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг ямар үзүүлэлтээр хэмждэг вэ /хувь/	20
Зураг 11. Санхүүгийн дэмжлэг, бүсээр	21
Зураг 12. Гэрлэлтийн байдал, ам бүлийн тоогоор	21
Зураг 13. Өрхийн сарын дундаж орлого, төсөл хөтөлбөрөөр	22
Зураг 14. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/	23
Зураг 15. Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан /хувь/	24
Зураг 16. Дэмжлэг авсан мөнгөн дүн /хувь/	27
Зураг 17. Хүссэн мөнгөн дүнгээ авсан эсэх /хувь/	27
Зураг 18. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл /хувь/	28
Зураг 19. Санхүүжилтээр авсан эд хөрөнгө, төсөл хөтөлбөрөөр /хувь/	28
Зураг 20. Зээлээ хугацаанд төлдөг эсэх, байршлаар /хувь/	29
Зураг 21. Эргэн төлөлт хийхгүй байгаа шалтгаан /хувь/	30
Зураг 22. Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/	30
Зураг 23. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авсан вэ /хувь/	32
Зураг 24. Тулгарсан хүндрэл бэрхшээл /хувь/	32
Зураг 25. Материалаа бүрдүүлэхэд хангалттай хугацаа байсан эсэх /хувь/	33
Зураг 26. Материалаа бүрдүүлэхдээ хаанаас туслалцаа авсан бэ /хувь/	33
Зураг 27. Төсөл шалгарсан хугацаа, төсөл хөтөлбөрөөр /хувь/	33
Зураг 28. Санхүүжилт хэдий хугацааны таны дансанд шилжсэн бэ /хувь/	34
Зураг 29. Процессын ил тод байдал /хувь/	34
Зураг 30. Мэргэжилтэн холбогдсон зорилго /хувь/	34
Зураг 31. Санхүүгийн дэмжлэгийн өмнөх сургалтад хамрагдсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/	38
Зураг 32. Санхүүгийн дэмжлэгийн дараах сургалтад хамрагдсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/	38
Зураг 33. Сургалтын орчин /хувь/	39
Зураг 34. Сургалтын төрөл /хувь/	40
Зураг 35. Гэрлэлтийн байдал, ам бүлийн тоогоор	40
Зураг 36. Өрхийн сарын дундаж орлого, арга хэмжээгээр /хувь/	41
Зураг 37. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг эсэх, арга хэмжээгээр /хувь/	42
Зураг 38. Сурахаар төлөвлөж байсан сургалт мөн эсэх, арга хэмжээгээр /хувь/	46
Зураг 39. Хүссэн мэргэжлээрээ суралцаж чадсан эсэх, сургалтын төрлөөр /хувь/	47
Зураг 40. Сургалтад хамрагдсан мэргэжлээрээ ажиллаагүй шалтгаан /хувь/	47

Зураг 41. Сургалтын орчин /хувь/.....	47
Зураг 42. Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх, арга хэмжээгээр /хувь/	48
Зураг 43. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийн эх сурвалж /хувь/...	50
Зураг 44. Сургалтад хамрагдахад хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх /хувь/.....	50
Зураг 45. Мэргэжилтэн холбогдсон зорилго /хувь/.....	50

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Насны бүлэг, төсөл хөтөлбөрөөр	22
Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн байдал	23
Хүснэгт 3. Статистик шинж чанар	25
Хүснэгт 4. Нэг ажил олгогчийн бий болгосон дундаж ажлын байр, байршлаар	29
Хүснэгт 5. Ажилтан нэмж авсан бизнес эрхлэгчдийн тоо, байршлаар	29
Хүснэгт 6. Хамрагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ, төсөл хөтөлбөрөөр	30
Хүснэгт 7. Хамрагдсан он, санхүүгийн дэмжлэгээр	31
Хүснэгт 8. Пробит загвар: Ажлын байр нэмсэн эсэх	35
Хүснэгт 9. Пробит загвар: Өрхийн амьжиргааны түвшин	36
Хүснэгт 10. Насны бүлэг, арга хэмжээгээр	40
Хүснэгт 11. Боловсролын түвшин, арга хэмжээгээр /хувь/	41
Хүснэгт 12. Хөдөлмөр эрхлэлтийн төрөл, арга хэмжээгээр /хувь/	42
Хүснэгт 13. Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, арга хэмжээгээр /хувь/	43
Хүснэгт 14. Статистик шинж чанар	44
Хүснэгт 15. Төлөвлөсөн сургалтандаа хамрагдаж чадаагүй шалтгаан, сургалтын төрлөөр /хувь/	46
Хүснэгт 16. Хамрагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ, арга хэмжээгээр	48
Хүснэгт 17. Хамрагдсан он, арга хэмжээгээр	49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХХҮЕГ- Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар

ХХЭ-Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээ нь ихэвчлэн ажилд зуучлах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, хөдөлмөрийн зах зээлийн бодлогоор зах зээлийн зохицуулалт хийх, ажилгүйдлийн тэтгэмжийн менежмент, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг.¹ Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого арга хэмжээ нь 2011 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар зохицуулагддаг.

Уг хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ гэж ангилдаг. Улсын хэмжээнд хэрэгжиж буй санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг хамруулан үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний судалгааг зохион байгуулж, хөтөлбөрүүдийн мэдээллийг нэгтгэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байр бий болгосон байдал зэрэг мэдээллийг бий болгохоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний судалгааг зохион байгууллаа.

Энэхүү судалгаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөдөлмөр эрхлэлтийн сургалт, санхүүгийн дэмжлэг)-ийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэг болон сургалтын үр дүнг тодорхойлох, бодлого боловсруулагч болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үндсэн зорилгыг агуулна.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, судалгаатай холбоотой асуудлаар санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ

М. БАТГЭРЭЛ

¹ The World of Public Employment Services, (2015). IDB, WAPES, OECD.

ХУРААНГУЙ

Судалгаанд нийт 21 аймаг 9 дүүргийн 38-н мэргэжилтэн хамрагдснаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хариуцсан 29-н мэргэжилтэн, Ажил мэргэжилийн чиг баримжаа олгох үйлчилгээ хариуцсан 7-н мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцаа хариуцсан 1 мэргэжилтэн, Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан 1 мэргэжилтэн хамрагдсан. 2024 онд хөдөлмөрт бэлтгэх сургалтанын үйл ажиллагаанд хамрагдсан 23377 иргэдээс 661 иргэнийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг авсан 7446 иргэдээс 536 иргэнийг санамсаргүй түүвэрлэн хамруулсан.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд олон ам бүлтэй, орлого багатай өрхийн гишүүд хамрагджээ. Өрхийн дундаж ам бүлийн тоо 4.6 байгаа нь улсын дунджаас нэлээд өндөр бөгөөд өрхийн тал нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага орлоготой байна. Сургалтанд хамрагдагсдын дундаж нас 38, дийлэнх 81% нь эмэгтэй талаас илүү 54% нь бүрэн дунд боловсролтой, дөрөвний гурав 73% нь гэрлэсэн байна. Сургалтанд хамрагдагсдын 52 хувь нь хөдөлмөр эрхэлдэг бөгөөд дийлэнх нь 72% цалин хөлстэй ажиллагч байна. Мэргэшил олгох сургалтанд хамрагдсан иргэдийн дөрөвний нэг 23% нь сурсан мэргэжлээрээ ажиллаж байгаа юм байна. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд сургалтын үйл ажиллагаатай харьцуулахад арай цөөн ам бүлтэй, орлого өндөртэй өрхийн гишүүд хамрагджээ. Өрхийн дундаж ам бүлийн тоо 3.7 байгаа нь улсын дундажтай ойролцоо бөгөөд өрхийн Гуравны хоёр нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээш орлоготой байна. Түүнчлэн судалгаанд хамрагдагсдын дундаж нас 51, дийлэнх 68% нь эмэгтэй, талаас илүү 52% нь бүрэн дундаас дээш боловсролтой, тавны дөрөв 80% нь гэрлэсэн байна. Иргэд дунджаар 7.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан бөгөөд 32 хувь нь гаргасан хүсэлтээсээ бага хэмжээгээр дэмжлэг авчээ. Санхүүгийн дэмжлэг нь 1.0 сая төгрөгөөс 10.0 сая төгрөгийн хооронд байна. Дэмжлэг авсан иргэдийн 77 хувь нь дэмжлэгийн өмнөх сургалтанд, 50 хувь нь дараах сургалтанд хамрагджээ. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн 95 хувьтай нь хөдөлмөрийн мэргэжилтнүүд холбогдсон бөгөөд голдуу бизнес нь хэвийн явж байгаа эсэх болон эргэн төлөлтийн талаар хяналт тавьдаг байна

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Үндэслэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд ХХҮЕГ 2024 оны байдлаар нийт 7,446 иргэн хамрагдсан байгаа бөгөөд Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1,572 иргэн, Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 3,319 иргэн, Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 66 иргэн, Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1,414 иргэн, Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 42 иргэн, Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 998 иргэн, Хүүхэд харах төв түрээсийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 36 иргэн тус хамрагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд 2024 онд нийт 23,377 иргэн хамрагдсан бөгөөд Суурь ур чадварын сургалтад 7,027 иргэн, Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтад 3,491 иргэн, Аж ахуй эрхлэлтийн сургалтад 8,829 иргэн, Залуучуудын сургалтын зөвлөгөөнд 3,095 иргэн, Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 935 иргэн тус тус хамрагдсан байна.

Иймд улсын хэмжээнд хэрэгжиж буй санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг хамруулан үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний судалгааг зохион байгуулж, хөтөлбөрүүдийн мэдээллийг нэгтгэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байр бий болгосон байдал зэрэг мэдээллийн сан үүсгэх, бий болгохоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний судалгааг зохион байгуулах гэж байна.

1.2 Зорилго, зорилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөдөлмөр эрхлэлтийн сургалт, санхүүгийн дэмжлэг)-ийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэг болон сургалтын үр дүнг тодорхойлох, бодлого боловсруулагч болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үндсэн зорилгыг агуулна.

Энэхүү судалгаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй дараах санхүүгийн дэмжлэгүүдэд хамрагдсан иргэн хамрагдана. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох
- Ахмадад санхүүгийн дэмжлэг олгох

Сургалтуудын хувьд дараах сургалтад хамрагдсан иргэдийг хамруулна.

- Суурь ур чадварын сургалт
- Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт
- Аж ахуй эрхлэлтийн сургалт
- Залуучуудын сургалт, зөвлөгөө
- Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадварын сургалт

Эдгээр санхүүгийн дэмжлэг болон сургалтууд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэдэг ч зорилго, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээрээ харилцан адилгүй байдаг.

1.3 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл

Энэхүү судалгаанд 2024 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний санхүүгийн дэмжлэг болон Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд хамрагдах ба энгийн санамсаргүй түүврийн аргаар иргэдийг сонгон шалгаруулсан.

1.4 Судалгааны арга зүй, зохион байгуулалт

Тоон судалгааны асуулгын болон ганцаарчилсан ярилцлагын арга, энгийн санамсаргүй түүврийн аргыг тус судалгаанд ашигласан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ижил төстэй хөтөлбөрүүдэд үнэлгээ хийсэн аргачлал, үр дүнгийн хувьсагчид, тэдгээрийг хэмжих тоон өгөгдлийн талаар мэдээлэл цуглуулан ажилласан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг дүүргийн газар, хэлтсүүдийн удирдлагаас томилогдсон холбогдох мэргэжилтэн нараас бүрдсэн хамтарсан баг гүйцэтгэсэн.

Дээр дурдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг болон сургалтуудын хэрэгжилттэй холбоотой тоон мэдээлэлд шинжилгээ хийж, мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн зорилго, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд үндэслэн үр дүнгийн хувьсагчдыг тодорхойлсон.

Судалгааны ажил нь дараах үндсэн үе шатуудаас бүрдсэн. Үүнд:

1. Судалгааны бэлтгэл ажил
2. Мэдээлэл цуглуулах
3. Мэдээлэл боловсруулах

1. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд

- Холбогдох эрх зүйн баримт бичиг судлах
- Судалгааны арга зүйг тодорхойлох, ажлын төлөвлөгөө график батлуулах
- ХХҮЕГ- аас холбогдох мэдээллийг авах
- Судалгааны ажлын удирдамж, хөтөлбөр боловсруулах
- Судалгааны асуулга, гарын авлага шинэчлэн, боловсруулж, турших
- Асуулгын хуудсыг эцэслэж бэлэн болгох

2. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд судалгааны талаар зааварчилгаа мэдээллийг өгч мэдээлэл цуглуулалтын багийг бүрдүүлэх.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдтэй хамтран мэдээлэл цуглуулалт хийх.
- Мэдээлэл цуглуулалтын Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд хяналт тавьж ажиллах
- Цуглуулсан дата мэдээллийг тайлан бичихэд бэлэн болгох үүднээс цаасан маягтын мэдээллийг шивж оруулах.

3. Боловсруулалт хийх ажлын хүрээнд

Судалгааны мэдээллийг анализ хийх зориулалтын программд шивж оруулах, үр дүнг боловсруулж, шинжилгээ хийхэд STATA, R программ хангамжийг ашиглана. Дараах ажлууд хийж гүйцэтгэсэн.

- Мэдээллийн санд хяналтын ажлыг хийх.
- Мэдээллийн тойм бэлдэх /outline/
- Үр дүнгийн хүснэгт, график бэлтгэх
- Судалгааны үр дүнгийн тайланг бэлэн болгох.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2024 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 4 үйл ажиллагаа, 25 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Үндсэн 4 үйл ажиллагаа:

- Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа,
- Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа,
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа

2.1 Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 2024 оны байдлаар нийт 7,446 иргэн хамрагдсан ба хамрагдсан иргэдийн 44.6 хувь нь малчдыг малжуулах үйл ажиллагаанд, 21.1 хувь нь иргэн, аж ахуй эрхлэгчид санхүүгийн дэмжлэг, 19.0 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, 13.4 хувь нь түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх, үлдсэн 1.9 хувь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 53.7 хувь нь малчдыг малжуулах арга хэмжээ, 25.6 хувь нь иргэн, аж ахуй нэгжийн санхүүгийн дэмжлэг, 17.6 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, үлдсэн 3.1 хувь нь бусад үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

Судалгааны хамрах хүрээнд 2024 оны санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны доорх 3 арга хэмжээ багтах бөгөөд зохион байгуулалт дараах байдлаар явагдсан.

1. Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг нь аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 25 ба түүнээс дээш насны иргэн, мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчийн боловсруулсан ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилготой төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, Засгийн газрын тогтоосон хувь хэмжээгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай нэг удаа олгогддог. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулах болон шалгарсан төсөл бүхий иргэний төслийн талаар ил тод нээлттэй байдлаар зохион байгуулах гэсэн 2 үе шаттай явагдах ба үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангаж, шударга өрсөлдөх боломжийг бүрэн хангасан байдлаар зохион байгуулна.
2. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох төсөл хөтөлбөр нь аймаг, дүүргийн болон улсын хэмжээнд зохион байгуулагддаг.
 - Улсын хэмжээний шилдэг “Старт-Ап”-ийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн жилийн 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба эргэн төлөгдөх нөхцөлгүй 1,2,3 дугаар байрт 6 залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулна. Улсын хэмжээнд шалгарсан залуу,

эсхүл залуучуудын багийг аймаг, дүүргийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгт давхардуулан хамруулахгүй.

- Аймаг, дүүргийн шилдэг гарааны бизнест дэмжлэг олгох үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилийн 3 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулж, 10,000,000 төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгодог.
3. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг нь аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настны боловсруулсан төслийг харьяа аймаг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хүлээн авч сонгон шалгаруулах ба төсөлд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр байна. Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх ба иргэний саналын дагуу эргэн төлөлтийн хуваарийг тогтоож, гэрээнд тусгана.

2.2 Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа

Хөдөлмөрт эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд 2024 оны байдлаар 23,377 иргэн хамрагдсан ба хамрагдсан иргэдийн 37.8 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 30.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 14.9 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 13.2 хувь нь залуучуудын сургалтын зөвлөгөө, 4.0 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 50.3 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 14.5 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 14.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 12.3 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт, 8.7 хувь нь залуучуудын сургалт, зөвлөгөө зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

1. Суурь ур чадварын сургалтад ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, хоригдож буй иргэн, орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэн хамрагдах боломжтой. Сургалтыг мэргэшсэн зөвлөх багшаар, эсхүл мэргэшсэн зөвлөх бүхий сургалтын байгууллагаар, эсхүл эдгээрийг хослуулан гэрээний дагуу өдрөөр, цагаар зохион байгуулна. Сургалтад хамрагдсан иргэдийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлно.
2. Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн, 21 аймаг, алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрэлтэд үндэслэн зохион байгуулдаг бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар тайлан гаргадаг. Сургалтын хугацааг хувь хүний эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чадамжийн нэгжийн хөтөлбөрт үндэслэн уян хатан тогтоож болох бөгөөд нийт үргэлжлэх хугацаа нь 3-6 долоо хоног, 7 хоногийн сургалт нь 36-аас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.
3. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч хамрагдах бөгөөд Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь өөрийн мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтан, эсхүл сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр сургалтыг зохион байгуулдаг. Энэхүү сургалтад жижиг зээл,


санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдахгүй иргэд сургалтад хамрагдах боломжтой. Сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд сургалт 21 академик цагаас доошгүй хөтөлбөртэй байна.

4. Залуучуудын сургалтын хөтөлбөр нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “In business” сургалтын модулийн дагуу явагддаг. Сургалтын зохион байгуулалтын хувьд ажил олгогчдын байгууллагаас хамтран 2 өдрийн сургалтын арга хэмжээнд бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын 15-34 насны залуучуудыг хамруулан зохион байгуулсан.
5. Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад ажил хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд, гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд хамрагдах ба хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн хөдөлмөр эрхлэх ур чадварт хийсэн үнэлгээнд үндэслэн мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон сургалт зохион байгуулагдсан. Үүнд:
 - Цахим ур чадвар эзэмшүүлэх;
 - Мэргэжлийн ур чадвар нэмэгдүүлэх;
 - Хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар дээшлүүлэх.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД

Судалгаанд нийт 38-н мэргэжилтэн хамрагдснаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хариуцсан 29-н мэргэжилтэн, Ажил мэргэжилийн чиг баримжаа олгох үйлчилгээ хариуцсан 7-н мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцаа хариуцсан 1 мэргэжилтэн, Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан 1 мэргэжилтэн хамрагдсан. Мэргэжилтнүүдийг ажилласан жилээр авч үзвэл 34.2% нь 10-аас дээш жил ажилласан байна. Судалгаанд оролцсон бүх мэргэжилтнүүд бакалаврын түвшний боловсролтой байна. Албан тушаалын хувьд авч үзвэл эдийн засагчид 21.1% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол нягтлан бодогчид болон эрх зүйчид тус бүр 15.8%-ийг эзэлсэн байна.

Зураг 1. Ажил чиг үүргийн хүрээнд тулгардаг хүндрэл бэрхшээл /хувь/



Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ямар нэг хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх талаар тодруулахад 55.3% нь тулгардаг гэсэн байгаа бол 44.7% нь тулгардаггүй гэсэн хариултыг өгсөн байна. Хүндрэл бэрхшээл тулгардаг гэсэн хариултыг өгсөн мэргэжилтнүүдээс ямар бэрхшээл тулгардаг талаар тодруулан асуухад доорх байдлаар хариулсан. Ажил мэргэжилийн чиг үүргийн хүрээнд тулгардаг хүндрэл бэрхшээлийн хувьд авч үзвэл 27.3% нь “Ажлын ачаалал их” гэсэн байгаа бол “Зорилтот бүлгийн гишүүдтэй харилцах” 22.7% нь сонгосон байна. Ажлын ачаалал их гэсэн хариултын хүрээнд танай алба хэлтсийн орон тоо бүрэн эсэх талаар тодруулахад нийт судалгаанд оролцсон мэргэжилтнүүдийн 23.7% нь бүрэн бус гэж хариулсан байна. Орон тооны хувьд дутагдалтай байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлэх асуудал болж байна.

Зураг 2. Мэдээлэл түгээж буй байдал /хувь/



Тухайн жилд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг иргэн, аж ахуй нэгжид ямар эх сурвалж ашиглан мэдээллийг


хүргэдэг талаар тодруулахад 36.5% “Цахим сүлжээ”, харин 26.0% нь “Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, хэлтсийн мэргэжилтэн” гэсэн хариултууд тус тус өндөр хувийг эзэлж байна. Энэ нь мэдээлэл түгээхэд цахим орчны үр нөлөө өндөр байгааг харуулж байна. Мөн бусад гэсэн сонголтыг авч үзвэл хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх өдөрлөгт мэдээллээ иргэдэд хүргэсэн гэсэн байна.

Зураг 3. Хүсэлт гаргасан иргэдийн бүртгэлийг хадгалж байгаа байдал, байршлаар /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хүсэлт гаргасан иргэдийн мэдээлэл, бүртгэлийг хадгалдаг эсэх талаар тодруулахад 94.7% нь хадгалдаг гэсэн хариултыг сонгосон байгаа бол 5.3% нь хадгалдаггүй гэсэн хариултыг сонгосон байна. Нийт оролцогчдыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хүсэлт гаргасан иргэдийн мэдээлэл, бүртгэлийг ямар байдлаар хадгалдаг талаар тодруулахад “excel, word файл”-аар хадгалдаг гэсэн сонголт хоёрны нэгийг буюу 48.3%-ийг эзэлж байна. Мөн 25.9% нь буюу дөрөвний нэг нь “Цаасан хэлбэрээр” хадгалдаг гэсэн хариултыг өгсөн байгаа нь цахим хэлбэрт буюу “И-жоб платформ”-д бүрэн шилжээгүй байгааг илтгэж байна. Дээрх зургаар Улаанбаатар болон орон нутгийн ялгаагаар дээр байдлаар харагдаж байна.

Зураг 4. Санхүүжилтийн квот хүсэлтийн дагуу ирдэг эсэх, байршлаар /хувь/



Тухайн жилийн санхүүжилтийн хэмжээ нь хүссэн хэмжээгээр ирдэг эсэхийг тодруулахад 63.2% нь буюу гуравны нэг нь хүсэлтээс бага ирдэг гэсэн хариултыг өгчээ.

Зураг 5. Ямар шалтгааны улмаас хүсэлтээс бага ирдэг вэ /хувь/




Ямар шалтгааны улмаас хүсэлт гаргасан хэмжээнээс бага байдаг талаас тодруулахад талаас илүү хувь нь буюу 54.3% нь “Төсвийн хязгаарлалт, хүрэлцээний асуудал дүүргийн хоорондын квотыг тэнцвэржүүлэхийн тулд” хариултуудыг сонгожээ.

Зураг 6. Иргэдийн гомдол, саналыг хэрхэн шийдвэрлэдэг вэ /хувь/



Иргэдийн гомдол саналыг шийдвэрлэх тал дээр хоёрны нэг нь буюу тал хувь нь учир шалтгааныг тайлбарлаж өгдөг бол дараагийн өндөр хувь эзлэх үзүүлэлт нь 21.1% буюу журмын дагуу шийдвэрлэдэг гэсэн хариултыг өгсөн байна.


Зураг 7. Өмнө нь тухайн арга хэмжээнд хамрагдаж байсанг шалгадаг уу /хувь/



Тухайн жилд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хүсэлт гаргаж буй иргэдийн мэдээллийн давхардлыг, хамрагдаж байсан эсэх талаар хариулахад бүгд шалгадаг гэсэн хариултыг өгсөн ба тухайн жилд төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэн дахин өөр төсөл хөтөлбөрт хамрагдах боломжгүй гэдгийг илтгэж байна. Давхардлыг сайн шалгадаг байна. Хэрхэн шалгадаг талаар тодруулахад дээрх байдлаар хариулсан байна. Тодруулбал 49.2% нь буюу хоёрны нэг нь “Цахим бүртгэлийн

систем ашиглах” гэсэн хариултыг өгсөн байгаа нь мэдээ мэдээлэл цахимжих байдалруу шилжиж байгааг илтгэж байгаа ч “Бүрдүүлсэн материалын бүртгэлээр давхцал шалгах”, “Өмнө нь хамрагдсан хүмүүсээ таньдаг”, “Иргэдийн мэдээллийг гар аргаар шалгах” гэсэн хариултууд нь мөн хоёрны нэгийг эзэлж байгаа нь мэдээ мэдээллийг “И-Жоб” платформд бүртгээж мэдээллийг цахимжуулах шаардлагатай байгааг нэг талаараа илтгэж байна.

Зураг 8. Хэрэгжилтэнд хяналт тавьдаг уу /хувь/



Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэнд 94.7% нь хяналт тавьдаг гэж хариулсан бол 5.3% нь хяналт тавьдаггүй

Зураг 9. Сургалтын хүрээнд ямар нэгэн дэмжлэг үзүүлдэг үү /хувь/



Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд хяналт хийх зорилгоор хэрхэн холбогддог талаар тодруулахад 30.1% нь буюу гуравны нэг нь “Бусад төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар мэдээлэл өгөх” гэсэн хариултыг өгсөн байна.

Зураг 10. Санхүүгийн дэмжлэгийн хүрээнд ямар хяналт хийдэг вэ /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийн хүрээнд хяналт хийх зорилгоор хэрхэн холбогддог талаар тодруулахад 34.7% нь “Эргэн төлөлттэй

холбоотойгоор” холбогдож хяналт хийдэг гэсэн бол 31.9% нь “Төслийн зориулалтаар мөнгө зарцуулагдсан эсэхийг шалгах” байдлаар хяналт хийх холбогддог гэсэн хариултыг өгсөн байна. Үүнээс харахад санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдтэйгээ эргэх холбоо сайн байгааг илтгэж байна.

Зураг 11. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг ямар үзүүлэлтээр хэмждэг вэ /хувь/



Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг ямар үзүүлэлтээр хэмждэг талаар тодруулахад дээрх байдлаар хариулсан байна. Тодруулбал 32.7% нь “Ажлын байрны нэмэгдсэн” байдлаар үр дүнг хэмждэг гэсэн бол 31.6% нь “Ажлын байраа хадгалж үлдсэн” байдлаар үр дүнг хэмждэг гэсэн хариултыг өгсөн байна.


БҮЛЭГ 4. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санхүүжилтийн 50 орчим хувийг эзэлдэг томоохон арга хэмжээ юм. Энэ хэсэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн нийгэм эдийн засгийн шинж чанар, санхүүгийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлт, шинээр бий болгосон ажлын байр зэргийг шинжилнэ. Бид энэхүү судалгаанд 2024 онд санхүүгийн дэмжлэг авсан 7446 иргэдээс 536 иргэнийг санамсаргүй түүвэрлэн хамруулсан.

4.1 Ерөнхий мэдээлэл


Судалгаанд хамрагдсан иргэдийг бүсээр харвал хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санхүүгийн дэмжлэгийн хувьд 31.9% нь Улаанбаатар хотын, үлдсэн 68.1 % нь орон нутагт хамрагдсан иргэд байна

Зураг 12. Санхүүгийн дэмжлэг, бүсээр



Судалгаанд нийт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт нийт 536 иргэн хамрагдсан бөгөөд “Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг”-т 268 иргэн, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санхүүгийн дэмжлэг”-т 249 ахмад настан, “Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг”-т 19 залуучууд судалгаанд хамрагдсан байна. Бүс нутгийн ялгаагаар дээрх зурагт харуулав.


Зураг 13. Гэрлэлтийн байдал, ам бүлийн тоогоор



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийг гэрлэлтийн байдлаар нь харвал 72.2% нь гэрлэсэн, батлуулсан байгаа бол 12.1% нь

бэлэвсэн гэсэн хариултыг өгсөн байна. Гэрлэлтийн байдлыг ам бүлийн тоогоор харвал гэрлэлтээ батлуулсан 2 ам бүлтэй өрх хамгийн их байна.

Зураг 14. Өрхийн сарын дундаж орлого, төсөл хөтөлбөрөөр



Өрхийн сарын дундаж орлогын хувьд авч үзвэл 31.9% нь 1,000,001-2,000,000 орлоготой гэсэн байгаа бол дараагийн өндөр хувийг 25.0% нь 2,001,000-3,000,000 орлоготой иргэд эзэлж байна. Орлогын хувьд авч үзвэл дунджаас дээгүүр орлоготой иргэд ихэнх хувийг эзэлж байна.


Хүснэгт 1. Насны бүлэг, төсөл хөтөлбөрөөр

	Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	Нийт
Насны бүлэг				
16-25	1	0	2	3
26-35	76	0	14	90
36-45	111	3	2	116
46-54	70	8	0	78
55+	10	238	1	249
Нийт	268	249	19	536

Насны бүлгийг төсөл хөтөлбөрөөр дээрх хүснэгтэд харуулсан байгаа бөгөөд “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-т аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй сонгон шалгаруулалтад тэнцсэн ахмад (өндөр настны, цэргийн, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон хүн) хамрагддаг бөгөөд дээрх хүснэгтээс харахад 36-45 насны 3-н иргэн, 46-54 насны 8-н иргэн хамрагдсан тохиолдол илэрсэн байна. Энэхүү нийт 11 хүний 3 нь аврагч болон гал сөнөөгч мэргэжилтэй байгаа нь цэргийн, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон байж болох юм. Тийм учраас нийт 8-н тохиолдол илэрсэн байна. Мөн “Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг”-т 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн,

ажил идэвхтэй хайж байгаа залуучууд хамрагддаг² бөгөөд тус санхүүгийн дэмжлэгт хамрагдсан нийт залуучуудын 2 иргэн 36-45 нас, 1 иргэн 55+ насны иргэн байгаа тохиолдол илэрсэн байна.

Зураг 15. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/



Нийт санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн хүрээнд цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодруулахад 80.4% нь хөдөлмөр эрхэлдэг гэж хариулсан байна. Санхүүгийн дэмжлэгийн төрлөөр харвал “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-т хамрагдсан иргэдийн 27.7% нь хөдөлмөр эрхэлдэггүй гэж хариулсан байна.

Хүснэгт 2. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Хөдөлмөр эрхлэлтийн байдал		Иргэнд олгох	Ахмад настанд олгох	Залуучуудад олгох
Цалин хөлстэй ажиллагч	Байнгын ажиллагч	42.1	31.7	25.0
	Түр ажиллагч	0.9	1.7	0.0
	Тохиолдлын ажиллагч	0.4	0.6	0.0
Ажил олгогч	ААНБ-ын ү/а-ны эрхлэгч	7.2	5.0	25.0
	Зах зээлд чиглэсэн өрхийн ААЭ	9.4	6.1	12.5
	Мал аж ахуй эрхлэгч	0.4	0.6	0.0
	Бусад өрхийн ААЭ	6.8	6.1	0.0
	ААНБ-ын ү/а-ны эрхлэгч	5.5	4.4	6.3
	Зах зээлд чиглэсэн өрхийн ААЭ	17.9	23.3	31.3

² Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллгааг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж 2024 он

Ажилтан ажиллуулдаггүй	Мал аж ахуй эрхлэгч	0.4	1.1	0.0
	Газар тариалан эрхлэгч	0.0	2.8	0.0
	Бусад өрхийн ААЭ	4.3	10.0	0.0
	Хувь нэмрээ оруулагч гишүүн	4.7	6.7	0.0
		100	100	100

Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг 80.4%-ийг эзэлж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал хамгийн өндөр буюу 37.1% нь байнгын ажиллагч байгаа бол 20.7% нь ажилтан ажиллуулдаггүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгч байна. Цалин хөлстэй ажиллагч 38.8% байгаа бол ажил олгогч болон ажилтан ажиллуулдаггүй ажил олгогч үлдсэн 61.2%-ийг буюу өндөр хувийг эзэлж байгаа нь хувиараа бизнес эрхлэгчид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгааг харуулж байна.

Зураг 16. Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан /хувь/



Цалин хөлстэй хөдөлмөр эрхлээгүй 19.6%-ийг эзэлж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлээгүй шалтгааныг тодруулахад 40.2% нь “Бизнесийн үйл ажиллагаа түр зогссон” гэсэн хариултыг өгсөн байгаа бол 18.8% нь эрүүл мэндийн шалтгаан гэсэн хариултыг өгсөн байна. Харин дараагийн өндөр хувийг эзэлж байгаа “Бусад” гэсэн хариултыг 17.9% нь сонгосон байгаа бөгөөд тэтгэвэрт байдаг учир гэсэн хариултыг өгсөн байна.

Статистик шинж чанар

Бид санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн ажлын байр бий болгосон байдал болон өрхийн орлогын статусыг нас, хүйс, боловсрол, өрхийн ам бүл зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, санхүүгийн дэмжлэгийн төрөл, санхүүжилтийн хэмжээ, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан байдалтай хамааруулан шинжилсэн. Хүснэгт 3-д шинжилгээнд ашигласан хувьсагчдын статистик шинж чанарыг харууллаа.

Хүснэгт 3. Статистик шинж чанар

	Ажиглалтын тоо	Дундаж	Медиан	Ст.Хаз	Минимум	Максимум
Нийгэм эдийн засгийн шинж чанар						
Ам бүлийн тоо	536	3.67	4	1.69	1	9
Өрхийн орлого 500000₮ хүртэл	536	0.02	0	0.14	0	1
500000-1000000	536	0.17	0	0.38	0	1
1000000-2000000	536	0.32	0	0.47	0	1
2000000-3000000	536	0.25	0	0.43	0	1
3000000₮-өөс их	536	0.24	0	0.43	0	1
Эмэгтэй	536	0.68	1	0.47	0	1
Нас	536	51.11	52	13.82	20	86
Гэрлэсэн	536	0.8	1	0.4	0	1
Бүрэн дунд	536	0.4	0	0.49	0	1
МСҮТ	536	0.09	0	0.29	0	1
Тусгай дунд	536	0.1	0	0.3	0	1
Дээд	536	0.33	0	0.47	0	1
Санхүүгийн дэмжлэгийн шинж чанар						
Санхүүгийн дэмжлэгийн төрөл	536	1.54	1.5	0.57	1	3
Санхүүгийн дэмжлэг авсан (сая.төг)	536	7174.44	8000	2417.78	1000	10000
Санхүүгийн дэмжлэг хүссэн (сая.төг)	536	8418.84	10000	2761.29	1000	25000
Хүссэнээс бага дэмжлэг	536	0.32	0	0.47	0	1
Хүссэнээс их дэмжлэг	536	0.02	0	0.14	0	1
Өмнөх сургалт	536	0.77	1	0.42	0	1
Дараах сургалт	536	0.5	0.5	0.5	0	1
Өмнө нь хамрагдсан	536	0.12	0	0.32	0	1
Хяналт, мониторинг	536	0.95	1	0.22	0	1
Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, орлогын шинж чанар						
Хөдөлмөр эрхэлдэг	536	0.87	1	0.34	0	1
Цалин хөлстэй ажиллагч	431	0.39	0	0.49	0	1
Ажил олгогч ХХЭ	431	0.22	0	0.41	0	1
ХХЭ	431	0.39	0	0.49	0	1
Дэмжлэгийн өмнөх ажлын байр	536	1.18	1	1.33	0	20
Нэмэгдсэн ажлын байр	536	0.86	0.5	1.31	0	15
Ажлын байр нэмсэн	536	0.5	0.5	0.50	0	1
Ядуу биш өрх	536	0.66	0	0.47	0	1

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд сургалтын үйл ажиллагаатай харьцуулахад арай цөөн ам бүлтэй, орлого өндөртэй өрхийн гишүүд хамрагджээ. Өрхийн дундаж ам бүлийн тоо 3.7 байгаа нь улсын дундажтай ойролцоо бөгөөд өрхийн Гуравны

хоёр нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээш орлоготой байна. Түүнчлэн судалгаанд хамрагдагсдын дундаж нас 51, дийлэнх (68%) нь эмэгтэй, талаас илүү (52%) нь бүрэн дундаас дээш боловсролтой, тавны дөрөв (80%) нь гэрлэсэн байна.


Иргэд дунджаар 7.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан бөгөөд 32 хувь нь гаргасан хүсэлтээсээ бага хэмжээгээр дэмжлэг авчээ. Санхүүгийн дэмжлэг нь 1.0 сая төгрөгөөс 10.0 сая төгрөгийн хооронд байна. Дэмжлэг авсан иргэдийн 77 хувь нь дэмжлэгийн өмнөх сургалтанд, 50 хувь нь дараах сургалтанд хамрагджээ. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн 95 хувьтай нь хөдөлмөрийн мэргэжилтнүүд холбогдсон бөгөөд голдуу бизнес нь хэвийн явж байгаа эсэх болон эргэн төлөлтийн талаар хяналт тавьдаг байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн 87 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг байна. Тэдний 39% нь цалин хөлстэй ажиллагч бол 22% нь ажил олгогч хувиараа хөдөлмөр эрхлэгч, 39% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч юм байна. Санхүүгийн дэмжлэг авахын өмнө дунджаар 1.1 ажлын байртай байсан бол тал нь шинж ажлын байр нэмснээр, судалгаа авах үед дунджаар 2 ажлын байртай болжээ.

4.2 Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа


Энэ хэсэгт санхүүгийн дэмжлэг олгрх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн нийгэм эдийн засгийн шинж чанар, сургалтын үйл ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийн байдлыг шинжилнэ.

Зураг 17. Дэмжлэг авсан мөнгөн дүн /хувь/



Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн санхүүгийн дэмжлэг авсан мөнгөн дүнг харвал 31.0% нь 5,000,000 төгрөг, 30.2% нь 10,000,000 төгрөгний санхүүгийн дэмжлэг авсан байна. Дээрхээс санхүүгийн дэмжлэгийн төрлөөр харж болно.

Зураг 18. Хүссэн мөнгөн дүнгээ авсан эсэх /хувь/




Хүссэн санхүүгийн дэмжлэгээ авсан эсэх талаар Улаанбаатар болон орон нутгийн ялгаагаар харахад нийт иргэдийн 66% нь хүссэн мөнгөн дүнгээ авсан байгаа бол 32.1% хүссэн мөнгөн дүнгээс бага санхүүжилт авсан байна. Улаанбаатар болон орон нутгийн ялгаагаар дээрх зургаар харуулав. Ихэнх нь хүсэлт гаргасан хэмжээгээрээ санхүүгийн дэмжлэгээ авч чаддаг байгаа ч гаргасан хүсэлтээс бага санхүүжилт авдаг гуравны нэг хэсэг дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Зураг 19. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл /хувь/



Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр нь харвал талаас илүү хувь нь буюу 59.0% нь боловсруулах үйлдвэрлэлийн чиглэл байгаа бол 14.6% нь бусад үйлчилгээнд хамаарч байна. Боловсруулах үйлдвэрлэлд гар урлал, оёдол болон хоол үйлдвэрлэл, модон урлал, тавилга үйлдвэрлэл, мах махан бүтээгдэхүүн зэрэг зүйлс орж байгаа нь боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй иргэд санхүүгийн дэмжлэгт ихээр хамрагдсан байна. Дээрх зургаар Улаанбаатар болон Орон нутгийн ялгаагаар харуулав.

Зураг 20. Санхүүжилтээр авсан эд хөрөнгө, төсөл хөтөлбөрөөр /хувь/



Санхүүжилтээр авсан эд хөрөнгийг нийт судалгаанд харагдсан иргэдийн хувьд авч үзвэл 46.8% нь тоног төхөөрөмж, 23.1% нь эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх, 19.2 бараа материал, түүхий эд авахад тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 4. Нэг ажил олгогчийн бий болгосон дундаж ажлын байр, байршлаар

	Obs	Mean	Std. Dev.	Min	Max
Улаанбаатар	171	1.0	1.6	0	15
Орон нутаг	365	0.8	1.2	0	9
Нийт	536	0.9	1.3	0	15


Улаанбаатар хотод нийт 35 бизнес эрхлэгч 10 хүртэлх ажлын байрыг бий болгожээ. Харин орон нутагт нийт 158 бизнес эрхлэгч 12 хүртэлх ажилтан нэмж авсан буюу шинэ ажлын байрыг бий болгосон байна.

Хүснэгт 5. Ажилтан нэмж авсан бизнес эрхлэгчдийн тоо, байршлаар

№	Ажилтны тоо		Улаанбаатар		Орон нутаг		Нийт	
		Давтамж	Эзлэх хувь	Давтамж	Эзлэх хувь	Давтамж	Эзлэх хувь	
1	0	73	42.7	195	53.4	268	50	
2	1	55	32.2	105	28.8	160	29.9	
3	2	28	16.4	46	12.6	74	13.8	
4	3	9	5.3	6	1.6	15	2.8	
5	4	2	1.2	7	1.9	9	1.7	
6	5	1	0.6	1	0.3	2	0.4	
7	6	2	1.2	4	1.1	6	1.1	
8	9	0	0.0	1	0.3	1	0.2	
9	15	1	0.6	0	0.0	1	0.2	
Нийт		171	100	365	100	536	100	

Судалгаанд хамрагдсан бичил бизнес эрхлэгчид 1084 ажилтантай (зээл авахаас өмнөх ажилчдын тоо 635, нэмж авсан ажилчдын тоо 459) байна. Улаанбаатар хотын хувьд нийт 171-н бичил бизнес эрхлэгч 178-н ажлын байрыг бий болгосон байгаа бол орон нутгийн хувьд 365-н бизнес эрхлэгч 281 ажлын байрыг бий болгосон байна.

Зураг 21. Зээлээ хугацаанд төлдөг эсэх, байршлаар /хувь/




Зээлээ хугацаанд нь төлдөг эсэх талаарх мэдээллийг байршлаар харахад Улаанбаатар хотын хувь 86% нь эргэн төлөлтөө хугацаанд нь төлдөг байгаа бол орон нутгийн хувь 18.4% нь эргэн төлөлтөө хугацаанд нь төлдөггүй байна.

Зураг 22. Эргэн төлөлт хийхгүй байгаа шалтгаан /хувь/



Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь төлөхгүй байгаа шалтгаануудыг харвал 43.4% нь орлого тогтворгүй, хүрэлцээгүй байдлаас болж байгаа гэсэн бол 20.4% нь бусад гэсэн хариултыг өгсөн байна. Бусад гэсэн хариултыг тодруулан бичвэл “эрүүл мэндийн шалтгаан” болон “төлөлтийг бүтнээр хийнэ” гэсэн хариултуудыг өгсөн байна.

Зураг 23. Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/



Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх талаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 88.3% нь хамрагдаж байгаагүй гэсэн хариултыг өгсөн байгаа бол 11.8% нь хамрагдаж байсан байна. Санхүүгийн дэмжлэгийн ялгаагаар харвал “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-т хамрагдсан ахмадуудын 16.1% нь хамрагдаж байсан гэж хариулсан байна.

Хүснэгт 6. Хамрагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ, төсөл хөтөлбөрөөр

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээ	Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	Нийт
1	Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох	14	14	1	29
2	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	0	17	0	17
3	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	3	3	2	8
4	Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг	1	0	0	1

5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	0	4	0	4
6	Суурь ур чадварын сур	1	0	0	1
7	Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	1	1	0	2
8	Аж ахуй эрхлэлтийн сургалт	0	1	0	1
Нийт		20	40	3	63

Нийт 63 иргэн өмнө нь төсөл хөтөлбөр арга хэмжээнд хамрагдаж байсан. 2024 онд авсан санхүүгийн дэмжлэгийн төрөлдөө өмнө хамрагдаж байсан эсэх талаар харвал 14 иргэн “Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох” -т, 17 ахмад “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-т, 3 залуучууд “Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг”-т өмнө нь хамрагдсан байна.

Хүснэгт 7. Хамрагдсан он, санхүүгийн дэмжлэгээр

Хамрагдсан он	Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	Нийт
2000	1	1	0	2
2001	0	1	0	1
2010	0	1	0	1
2012	0	2	0	2
2013	0	2	0	2
2014	0	2	0	2
2015	0	3	0	3
2016	2	1	0	3
2017	3	2	0	5
2018	6	6	0	12
2019	3	3	1	7
2020	1	4	1	6
2021	1	9	0	10
2022	0	2	0	2
2023	3	1	1	5
Нийт	20	40	3	63

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журамд зааснаар “эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг авсан этгээд гэрээнд заасны дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан бол эргэн төлөлтийг төлж барагдуулснаас хойш 24 сарын дараа дахин санхүүгийн дэмжлэг авч болно гэж

заасан байдаг ³ . Дээрх хүснэгтээс харвал 2022 онд хамрагдсан 2 иргэн, 2023 онд хамрагдсан 5 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан тохиолдол гарсан байна.

Зураг 24. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авсан вэ /хувь/



Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг 51.2% нь “Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар хэлтэс”-ээс авсан бол 28.9% нь “Цахим сүлжээ” гэж хариулжээ. Үүнээс харахад хөдөлмөр халамж, үйлчилгээний мэргэжилтнүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийн иргэдэд тодорхой хэмжээнд хангалттай хүргэдэг гэдэг нь харагдаж байна.


Зураг 25. Ямар хүндрэл бэрхшээл тулгарсан бэ /хувь/



Энэ нь зөвхөн санхүүгийн дэмжлэг авсан хүмүүсийн хүрээнд ийм үр дүн гарч байгаа бөгөөд хамрагдаагүй санхүүгийн дэмжлэг авч чадаагүй хүмүүсийн хувьд ямар хүндрэл бэрхшээл тулгарч байсанг тодорхойлох боломжгүй юм. Хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх талаар тодруулахад 91.2% нь хүндрэл бэрхшээл гараагүй гэж хариулсан байна. Хүндрэл бэрхшээл тулгарсан гэж үзсэн 8.8%-ийг эзэлж байгаа иргэдийн хувьд ямар хүндрэл бэрхшээл тулгарсан талаар тодруулахад 28.8% нь шалгуур, шаардлага өндөр гэсэн хариултыг өгсөн байгаа бол 15.1% нь “Санхүүжилтийн хэмжээ, нөхцөл өндөртэй” гэсэн хариултыг өгсөн байна. Харин 11.0% нь бусад гэсэн сонголтыг хийсэн байгаа бөгөөд батлан даагч заавал харьяалал ижил хүн байх, төсөл бичих зэрэг асуудлууд тулгардаг гэсэн байна.

³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам

Зураг 26. Материалаа бүрдүүлэхэд хангалттай хугацаа байсан уу /хувь/




Санхүүгийн дэмжлэгт хамрагдахын тулд шаардлагатай материал хүлээн авах, бүрдүүлэх хугацаа хангалттай байсан эсэх талаар тодруулахад 67.9% нь хангалттай гэсэн байгаа бол 27.6% нь маш хангалттай гэсэн хариултыг өгсөн байна. Үүнээс харахад материал хүлээн авах хугацааг хангалттай өгдөг нь харагдаж байна.

Зураг 27. Материалаа бүрдүүлэхдээ хаанаас туслалцаа авсан бэ /хувь/




Материалаа бүрдүүлэхдээ хэнээс, хаанаас туслалцаа авсан талаар тодруулахад 27.7% нь “Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтэн” гэсэн байгаа бол 24.5% нь “Бусдаас туслалцаа аваагүй /өөрөө/” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 28. Төсөл шалгарсан хугацаа, төсөл хөтөлбөрөөр /хувь/




Таны төсөл шалгарсан тухай мэдээг материалаа бүрдүүлж өгснөөс хойш хэдий хугацааны авсанг санхүүгийн дэмжлэгийн төрлөөр харвал “Гарааны бизнес залуучуудад олгох санхүүгийн дэмжлэг”-т хамрагдсан залуучууд 57.9% нь 1-6 хоног гэж хариулсан байна. Энэхүү төсөл нь хамгийн хурдан, богино хугацаанд 1–6 хоногт шалгарч байна.

Зураг 29. Санхүүжилт хэдий хугацааны таны дансанд шилжсэн бэ /хувь/



Шалгарсан тухай мэдээг материалаа бүрдүүлж өгснөөс хойш хэдий хугацааны дараа санхүүжилт таны дансанд орсон талаар тодруулахад 7-14 хоногт шилжсэн гэсэн сонголтыг хийсэн байна.

Зураг 30. Процессын ил тод байдал



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн-ий ил тод байдалд “ил тод байсан” гэсэн үнэлгээ хамгийн өндөр хувьтай байна. Сонгон шалгаруулалтын процесс-ын хувьд “маш ил тод байсан” гэсэн үнэлгээ хамгийн өндөр буюу 64.4%-ийг эзэлж, ил тод байдлыг өндөр түвшинд хангаж байгааг харуулжээ. Ингэснээр процессын аль аль хэсэгт ил тод байдал сайн хангагдсан бөгөөд ялангуяа сонгон шалгаруулалтын үе шатанд ил тод байдал илүү өндөр түвшинд байна.

Зураг 31. Мэргэжилтэн холбогдсон зорилго /хувь/



Санхүүгийн дэмжлэг авснаас хойш мэргэжилтэн таньтай буцаж холбогдож байсан эсэр эргэх холбоотой ажилласан эсэх талаар асуухад 94.8% нь холбогдсон гэж хариулсан байна. Ямар зорилгоор холбогдсон талаар тодруулахад мэргэжилтнүүдийн хамгийн их нь (бараг тал хувь) бизнесийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхийг мэдэх зорилгоор холбогдсон байна. Үүний дараа төслийн мөнгөн зарцуулалт болон эргэн төлөлтийн асуудал давамгайлж байгаа бол ажил эрхлэлт, орлого зэрэг бизнесийн нарийвчилсан мэдээлэл авах зорилго харьцангуй бага хувийг эзэлжээ.

Регрессийн шинжилгээ

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдагсдын бизнесийн үйл ажиллагааны үр дүнг ажлын байр нэмсэн эсэх болон амьжиргааны баталгаажих

түвшнээс дээш орлоготой эсэхээр хэмжих ба эдгээр хувьсагчид судалгаанд оролцогсдын нас, хүйс, гэрлэлтийн байдал, боловсрол зэрэг нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд болон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, дэмжлэг нь хүсэлтээс нь бага эсэх, санхүүгийн дэмжлэгийн өмнөх болон дараах сургалтанд хамрагдсан байдал, дэмжлэг авахад хүндрэлтэй байсан эсэх зэрэг үзүүлэлтүүдтэй хамааралтай эсэхийг регрессийн загвараар шинжилнэ.

Санхүүгийн дэмжлэгийн үр дүнтэй холбоотой хоёр хувьсагчийг бинар утгатай буюу хоёр боломжит утга авдаг байхаар тодорхойлсон тул магадлалын загвараар хамаарлыг нь үнэлэх нь илүү тохиромжтой. Иймд бид энэ шинжилгээнд пробит регрессийн загвар ашиглана.

Бид тэгшитгэл (1)-ын пробит загварыг үнэлснээр ажлын байр нэмэх магадлал ба бусад тайлбарлагч хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээг хийх боломжтой.

$$\text{logit}(P(Y = 1)) = \ln\left(\frac{P(Y=1)}{1-P(Y=1)}\right) = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_k X_k \quad (1)$$

$P(Y = 1)$ нь хөдөлмөр эрхлэх магадлал, $\beta_0, \beta_1, \beta_2, \dots, \beta_k$ нь тайлбарлагч хувьсагчдын өмнөх коэффициентууд. $X_1, X_2, \dots, X_k$ нь тайлбарлагч хувьсагчид бөгөөд шинжилгээнд ашиглах тайлбарлагч хувьсагчид болон тэдгээрийн статистик үзүүлэлтүүдийг Хүснэгт 4-д харуулсан.

Ажлын байр шинээр нэмэх

Санхүүгийн дэмжлэг авсан иргэд шинээр ажлын байр нэмсэн эсэх нь нийгэм эдийн засгийн шинж чанарын хувьсагчид болон санхүүгийн дэмжлэгтэй холбоотой хувьсагчидтай хамааралтай эсэхийг үнэлсэн пробит загварын үр дүнг Хүснэгт 5 харуулж байна. Ажлын байр нэмэх магадлал нь боловсролын түвшин, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, дэмжлэгийн өмнөх сургалтанд хамрагдсан эсэхээс эерэг хамааралтай бол дэмжлэг авахад гарсан хүндрэлээс сөрөг хамааралтай байна. Харин иргэдийн нас, хүйс, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, дэмжлэг хүсэлтээс нь бага эсэх болон дэмжлэгийн дараах сургалттай хамааралгүй байна.

Хүснэгт 8. Пробит загвар: Ажлын байр нэмсэн эсэх

	Ажлын байр нэмсэн	
	Коэффициент	Маржинал нөлөө
Тогмтол	-4.883***	
Ам бүлийн тоо	-0.057	-0.021
Эмэгтэй	-0.119	-0.044
Нас	0.047	0.017
Насны квадрат	-0.001	0.000
Гэрлэсэн	0.100	0.037
Бүрэн дунд	0.839***	0.312***
МСҮТ	0.724**	0.269**
Тусгай дунд	0.727**	0.270**
Дээд боловсрол	1.000***	0.372***
Санхүүгийн дэмжлэгийн лог	0.314**	0.117**
Дэмжлэг хүссэнээс бага байсан	0.022	0.008

Өмнөх сургалт	0.273*	0.102*
Дараах сургалт	0.036	0.013
Дэмжлэг авахад хүндрэлтэй	-0.364*	-0.136*
Хяналт, мониторинг	0.341	0.127

Ажиглалтын тоо	535
AIC	726.93

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгааны өгөгдлөөс тооцоолов. * 10% ач холбогдлын түвшин, ** 5% ач холбогдлын түвшин, *** 1% ач холбогдлын түвшин.

Пробит загвараас хувьсагчдын дундаж маржинал нөлөөг үнэлсэн (Хүснэгт 5-ын хоёрдугаар багана). Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг хувиар өндөр бол шинэ ажлын байр нэмэх магадлал 0.12-оор өндөр байна. Харин дэмжлэг авах үед хүндрэлтэй байсан иргэдийн ажлын байр нэмэх магадлал 0.14-өөр бага байна. Түүнчлэн боловсролын түвшин ахих нь ажлын байр нэмэх магадлалыг 0.27-оос 0.37-оор өсгөж байна.

Өрхийн амьжиргааны түвшин

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны нэг зорилго нь иргэдийн амьжиргааг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх юм. Иймд энэ хэсэгт иргэдийн амьжиргааны түвшинг амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээш орлоготой эсэхээр хэмжсэн бөгөөд энэ үзүүлэлт нийгэм эдийн засгийн шинж чанарын хувьсагчид болон санхүүгийн дэмжлэгтэй холбоотой хувьсагчидтай хамааралтай эсэхийг үнэлсэн. Пробит загварын үнэлгээний үр дүнг Хүснэгт 6 харуулж байна.

Санхүүгийн дэмжлэг авсан өрх ядуу биш байх магадлал нь гэрлэлтийн байдал, дээд боловсрол, болон санхүүгийн дэмжлэгийн хэмжээнээс эерэг хамааралтай байгаа бол өрхийн ам бүлийн тооноос сөрөг хамааралтай байна. Түүнчлэн иргэдийн нас, хүйс, дэмжлэг хүсэлтээс нь бага эсэх болон дэмжлэгийн өмнөх болон дараах сургалттай хамааралгүй байна.

Хүснэгт 9. Пробит загвар: Өрхийн амьжиргааны түвшин

	Ядуу биш байх	
	Коэффициент	Маржинал нөлөө
Тогмтол	-1.065	
Ам бүлийн тоо	-0.467***	-0.135***
Эмэгтэй	-0.190	-0.055
Нас	0.017	0.005
Насны квадрат	0.000	0.000
Гэрлэсэн	0.358**	0.104**
Бүрэн дунд	0.071	0.020
МСҮТ	0.174	0.050
Тусгай дунд	0.033	0.010
Дээд боловсрол	0.582**	0.168**
Санхүүгийн дэмжлэгийн лог	0.339**	0.098**
Дэмжлэг хүссэнээс бага байсан	0.000	0.000

Өмнөх сургалт	-0.178	-0.051
Дараах сургалт	0.087	0.025
Дэмжлэг авахад хүндрэлтэй	0.081	0.023
Хяналт, мониторинг	-0.014	-0.004

Ажиглалтын тоо	535
AIC	583.51

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгааны өгөгдлөөс тооцоолов. * 10% ач холбогдлын түвшин, ** 5% ач холбогдлын түвшин, *** 1% ач холбогдлын түвшин.

Пробит загвараас хувьсагчдын дундаж маржинал нөлөөг үнэлсэн (Хүснэгт 6-гийн хоёрдугаар багана). Өрхийн орлого амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээгүүр байх магадлал ам бүлийн тоо нэгээр нэмэгдэхэд 0.13-аар бага байгаа бол гэрлэсэн иргэдийн хувьд 0.10, дээд боловсролтой иргэдийн хувьд 0.17 өндөр ба санхүүгийн дэмжлэг нэг хувиар өндөр бол 0.10-аар тус тус өндөр байдаг байна.

4.3 Аж ахуй эрхлэлтийн сургалт


Аж ахуй эрхлэлтийн сургалтад хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч хамрагдах бөгөөд Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь өөрийн мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтан, эсхүл сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр сургалтыг зохион байгуулдаг. Энэхүү сургалтад жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдахгүй иргэд сургалтад хамрагдах боломжтой. Сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд сургалт 21 академик цагаас доошгүй хөтөлбөртэй байна.

Зураг 32. Санхүүгийн дэмжлэгийн өмнөх сургалтанд хамрагдсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/




Нийт санхүүгийн дэмжлэгийн хүрээнд судалгаанд хамрагдсан иргэдийн 76.7% нь санхүүгийн өмнөх сургалтанд хамрагдсан байгаа бол 23.3% нь хамрагдаагүй байна.

Зураг 33. Санхүүгийн дэмжлэгийн дараах сургалтанд хамрагдсан эсэх, төсөл хөтөлбөрөөр /хувь/



Дээрх зургаар санхүүгийн дэмжлэг авсны дараах сургалтад хамрагдсан эсэхийг төсөл, хөтөлбөрөөр харьцуулан хариуллаа. Иргэн аж ахуй нэгжид олгох санхүүгийн дэмжлэг болон гарааны бизнес эрхлэгч залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд сургалтын оролцоо харьцангуй сайн байна. Судалгаанд оролцсон иргэ маань санхүүгийн дэмжлэгийн дараах сургалтаар бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт, санхүүгийн бүртгэл тооцоо зэрэг мэдлэгүүдийг олж авсан байна.

Зураг 34. Сургалтын орчин /хувь/



Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэдийн ихэнх хувь нь сургалтын орчин болон сургалтын материал, тоног төхөөрөмжийн хүртээмжтэй, тохилог байсан гэж үзсэн байна.

БҮЛЭГ 5. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь Монгол улсын хөгжлийн ур, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалга шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг мэргэжлийн болон суурь ур чадварын сургалтаар дамжуулан бэлтгэх, цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх талаарх мэдлэгийг олгох замаар хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

5.1 Ерөнхий мэдээлэл


Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаанд 2024 онд нийт 23,377 иргэн хамрагдсан бөгөөд Суурь ур чадварын сургалтад 7,027 иргэн хамрагдснаас 326 иргэн, Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтад 3,491 иргэн хамрагдснаас 162, Аж ахуй эрхлэлтийн сургалтад 8,829 иргэн хамрагдснаас 536 иргэн, Залуучуудын сургалтын зөвлөгөөнд 3,095 иргэн хамрагдснаас 63 иргэн, Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 935 иргэн хамрагдснаас 110 иргэн болон тус тус судалгаанд хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хариуцсан 38 мэргэжилтэн тус тус судалгаанд хамрагдсан.

Зураг 35. Сургалтын төрөл /хувь/



Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа нь дээрх хэлбэрүүдээр зохион байгуулагддаг бөгөөд “Аж ахуй эрхлэлтийн сургалт”-ыг дээр 4.3-р бүлэгт дэлгэрэнгүй дурьдсан болно. Бусад сургалтын үйл ажиллагааг энэхүү бүлэгт дурьдах болно.

Зураг 36. Гэрлэлтийн байдал, ам бүлийн тоогоор



Гэрлэлтийн байдлыг ам бүлийн тоотой нь харьцуулан харвал гэрлэсэн батлуулсан 5-н ам бүлтэй иргэд хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Хүснэгт 10. Насны бүлэг, арга хэмжээгээр

Сургалтын төрөл	Насны бүлэг				
	16-25	26-35	36-45	46-54	55+
Суурь ур чадварын сургалт	45	51	118	88	24

Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	19	56	64	18	5
Залуучуудын сургалт, зөвлөгөө	18	34	7	2	2
Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт	6	40	38	23	3
Нийт	87	181	227	131	34

Насны бүлгийг сургалтын төрлөөр дээрх хүснэгтээс харвал 36-45 насны иргэд хамгийн өндөр хамрагдалттай байгаа нь харагдаж байна. Мөн “Залуучуудын сургалт, зөвлөгөө”-д 15-34 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвүүдэд ажил олгогчдын байгуулагатай хамтран “in business” сургалтын модулийн дагуу зохион байгуулагддаг бөгөөд 35-аас дээш насны 11 хүн хамрагдсан тохиолдол гарсан байна.

Зураг 37. Өрхийн сарын дундаж орлого, арга хэмжээгээр /хувь/



Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн сарын дундаж орлогыг, арга хэмжээгээр харвал “Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт”-д хамрагдсан иргэдийн ихэнх нь буюу 30% нь 500,001-1,000-000-ын орлоготой байгаа бол “Залуучуудын сургалт зөвлөгөө”-д хамрагдсан иргэдийн 33.3% нь 2,001,000-3,000,000-ын орлоготой байна.


Хүснэгт 11. Боловсролын түвшин, арга хэмжээгээр /хувь/

	Суурь ур чадварын сургалт	Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	Залуучуудын сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт	Нийт
Боловсролгүй	3.7	0.0	0.0	0.9	2.0
Бага	1.8	0.6	1.6	2.7	1.7
Суурь	7.1	6.8	4.8	10.0	7.3
Бүрэн дунд	60.1	56.8	36.5	41.8	54.0

Тусгай мэргэжлийн дунд	5.8	4.3	7.9	0.9	4.8
Техникийн болон мэргэжлийн	3.7	2.5	0.0	2.7	2.9
Дипломын дээд	16.3	26.5	46.0	40.0	25.6
Бакалавр	1.5	2.5	3.2	0.9	1.8

Боловсролын түвшнээр харвал дээрх сургалтуудад хамрагдсан иргэдийн 54.0% нь бүрэн дунд боловсролтой буюу талаас илүү хувь нь сургалтанд хамрагдсан байгаа нь ажилгүй иргэн болон ажил хайхад хүндрэлтэй байгаа иргэдэд чиглэхийг зорьсон нь харагдаж байна.

Зураг 38. Цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг эсэх, арга хэмжээгээр /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал нийт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тал хувь нь хөдөлмөр эрхэлдэг, тал хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. “Эмэгтэйчүүдийн богино хугацааны ур чадвар олгох сургалт”-д хамрагдсан эмэгтэйчүүд цалин хөлстэй хөдөлмөр эрхлээгүй байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 12. Хөдөлмөр эрхлэлтийн төрөл, арга хэмжээгээр /хувь/

Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Суурь ур чадвар	Танхимын болон үйлдвэрлэл	Залуучуудын сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд олгох сургалт
Цалин хөлстэй ажиллагч				
Байнгын ажиллагч	59.2	75.3	73.2	48.8
Түр ажиллагч	4.5	5.4	4.9	9.3
Тохиолдлын ажиллагч	1.9	4.3	2.4	0.0

Дадлагажигч	0.0	1.1	0.0	0.0
Ажил олгогч				
ААНБ-ын ү/а-ны эрхлэгч	3.2	3.2	0.0	7.0
Зах зээлд чиглэсэн өрхийн ААЭ	5.1	1.1	9.8	2.3
Мал аж ахуй эрхлэгч	0.0	0.0	0.0	9.3
Бусад өрхийн ААЭ	0.6	0.0	0.0	2.3
Ажилтан ажиллуулдаггүй				
ААНБ-ын ү/а-ны эрхлэгч	2.6	3.2	0.0	4.7
Зах зээлд чиглэсэн өрхийн ААЭ	12.1	2.2	7.3	11.6
Мал аж ахуй эрхлэгч	4.5	4.3	0.0	2.3
Газар тариалан эрхлэгч	2.6	0.0	2.4	0.0
Бусад өрхийн ААЭ	3.8	0.0	0.0	2.3
Хувь нэмрээ оруулагч гишүүн	2.6	3.2	0.0	4.7
		100	100	100

Цалин хөлстэй ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн төрлийг арга хэмжээгээр авч үзвэл сургалт тус бүр дээр байнгын ажиллагчид хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 13. Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан, арга хэмжээгээр /хувь/

Хөдөлмөр эрхлээгүй шалтгаан	Суурь ур чадвар	Танхимын болон үйлдвэрлэл	Залуучуудийн сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд олгох сургалт
Суралцдаг	10.4	4.0	36.0	1.4
Эрүүл мэндийн шалтгаан	20.8	9.2	8.0	19.7
Жирэмсэн/ хүүхэд асарч байгаа	33.9	35.5	40.0	56.3
Өвчтөн/ өндөр настан асарч байгаа	8.2	2.6	0.0	1.4

Ажил хайгаад олдохгүй байгаа	9.8	19.7	4.0	4.2
Мэргэжил дадлага туршлага байхгүй	2.7	9.2	0.0	0.0
Мэргэжилд тохирох ажил олдохгүй	3.8	7.9	4.0	2.8
Бизнесийн үйл ажиллагаа түр зогссон учир	5.5	7.9	4.0	7.0
Бусад	4.9	4.0	4.0	7.0
	100.0	100.0	100.0	100.0

Нийт Цалин хөлстэй хөдөлмөр эрхлээгүй байгаа шалтгааны харвал 39.2 хувь нь жирэмсэн болон хүүхэд асарч байгаа гэсэн байна. Арга хэмжээ сургалтын төрлөөр харвал “Эмэгтэйчүүдийн богино хугацааны ур чадвар олгох сургалт”-д хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь буюу 56.3% нь жирэмсэн/хүүхэд асарч байгаа гэсэн хариулт өгсөн байна. Уг сургалтын хамрах хүрээ нь ажил хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд, гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд, хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хамруулдаг учир энэ үзүүлэлт нь хамгийн өндөр харагдаж байна.

Статистик шинж чанар

Бид сургалтанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нас, хүйс, боловсрол, өрхийн ам бүл зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, хүссэн сургалт, дадлага, сургалтын чанартай холбоотой үзүүлэлт зэрэг сургалтын үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлсээс хамааруулан шинжилсэн. Хүснэгт 14-д судалгаанд ашигласан хувьсагчдын статистик шинж чанарыг харууллаа.

Хүснэгт 14. Статистик шинж чанар

	Ажиглалтын тоо	Дундаж	Медиан	Ст.Хаз	Хамгийн бага	Хамгийн өндөр
Нийгэм эдийн засгийн шинж чанар						
Ам бүлийн тоо	661	4.61	5	1.62	1	12
Өрхийн орлого 500000₮ хүртэл	661	0.12	0	0.33	0	1
500000-1000000	661	0.25	0	0.43	0	1
1000000-2000000	661	0.33	0	0.47	0	1
2000000-3000000	661	0.19	0	0.39	0	1
3000000₮-өөс их	661	0.11	0	0.31	0	1
Эмэгтэй	661	0.81	1	0.39	0	1
Нас	661	38.21	38	10.44	15	66
Гэрлэсэн	661	0.73	1	0.45	0	1
Бүрэн дунд	661	0.54	1	0.5	0	1
МСҮТ	661	0.05	0	0.21	0	1

Тусгай дунд	661	0.03	0	0.17	0	1
Дээд	661	0.27	0	0.45	0	1
Сургалтын шинж чанар						
Хүссэн сургалт	661	0.77	1	0.42	0	1
Мэргэжил олгох сургалт	661	0.47	0	0.5	0	1
Хүссэн мэргэжлийн сургалт	310	0.89	1	0.32	0	1
Дадлага хийсэн	310	0.72	1	0.45	0	1
Багшийн ур чадвар (1-маш муу, 5-маш сайн)	613	4.11	4	0.62	1	5
Анги танхимын тохижилт (1-маш муу, 5-маш сайн)	613	3.9	4	0.7	1	5
Тоног төхөөрөмжийн хүртээмж (1-маш муу, 5-маш сайн)	613	3.81	4	0.8	1	5
Өмнө нь хамрагдсан	661	0.16	0	0.37	0	1
Хяналт, мониторинг	661	0.23	0	0.42	0	1
Хөдөлмөр эрхлэлтийн шинж чанар						
Хөдөлмөр эрхэлдэг	661	0.52	1	0.5	0	1
Цалин хөлстэй ажиллагч	335	0.72	1	0.45	0	1
Ажил олгогч ХХЭ	335	0.09	0	0.29	0	1
ХХЭ	335	0.19	0	0.39	0	1
Сурсан мэргэжлээрээ ажилладаг	310	0.23	0	0.42	0	1

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгааны өгөгдлөөс тооцоолов.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд олон ам бүлтэй, орлого багатай өрхийн гишүүд хамрагджээ. Өрхийн дундаж ам бүлийн тоо 4.6 байгаа нь улсын дунджаас нэлээд өндөр бөгөөд өрхийн тал нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага орлоготой байна. Сургалтанд хамрагдагсдын дундаж нас 38, дийлэнх (81%) нь эмэгтэй талаас илүү (54%) нь бүрэн дунд боловсролтой, дөрөвний гурав (73%) нь гэрлэсэн байна.


Иргэдийн 77 хувь нь хүссэн сургалтандаа хамрагдсан бөгөөд сургалтын чанарыг (багшийн ур чадвар, анги танхимын тохижилт, тоног төхөөрөмжийн хүртээмж) сайн гэж үнэлжээ. Эдгээр иргэдийн 16 хувь нь өмнө нь сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан байна. Түүнчлэн 47 хувь нь мэргэшил олгох сургалтанд хамрагдсан бөгөөд тэднээс 72 хувь нь дадлага хийжээ.

Сургалтанд хамрагдагсдын 52 хувь нь хөдөлмөр эрхэлдэг бөгөөд дийлэнх нь (72%) цалин хөлстэй ажиллагч байна. Мэргэшил олгох сургалтанд хамрагдсан иргэдийн дөрөвний нэг (23%) нь сурсан мэргэжлээрээ ажиллаж байгаа юм байна.

5.2 Сургалтын үйл ажиллагаа

Энэ хэсэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн нийгэм эдийн засгийн шинж чанар, сургалтын үйл ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийн байдлыг шинжилнэ.

Зураг 39. Сурахаар төлөвлөж байсан сургалт мөн эсэх, арга хэмжээгээр /хувь/



Нийт судалгаанд хамрагдсан иргэлийн хувьд өөрийн хүсэлтээр сурахаар төлөвлөж байсан сургалтандаа хамрагдаж чадсан иргэд 77% нь байгаа бол 33% нь төлөвлөсөн хүссэн сургалтандаа хамрагдаж чадаагүй байна. Хамрагдаж чадаагүй иргэдийг сургалтын төрлөөр нь харвал “Суурь ур чадварын сургалт” хамгийн өндөр буюу 32.2% нь буюу гуравны нэг нь хамрагдаагүй байна.


Хүснэгт 15. Төлөвлөсөн сургалтандаа хамрагдаж чадаагүй шалтгаан, сургалтын төрлөөр /хувь/

Хамрагдаж чадаагүй шалтгаан	Суурь ур чадвар олгох	Танхимын болон үйлдвэрлэл	Залуучуудийн сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд олгох сургалт	Нийт
Тухайн сургалтын хамрагдах иргэдийн тоо гүйцсэн	3.7	11.1	26.7	5.6	7.0
Хүссэн сургалт хөтөлбөрт байгаагүй	6.5	11.1	13.3	16.7	8.9
Сургалтын хуваарь нь өөрийн боломжит цагтай зөрөх	0.9	5.6	6.7	0.0	1.9
Сургалтын газар хол, очиход хүндрэлтэй	0.9	0.0	0.0	0.0	0.6
Мэргэжилтэн санал болгосон	70.1	38.9	20.0	50.0	59.5
Бусад /бичнэ үү/	17.8	33.3	33.3	27.8	22.2
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүссэн, төлөвлөсөн сургалтандаа хамрагдаж чадаагүй шалтгааны тодруулахад судалгаад оролцсон иргэдийн 59.5% нь буюу талаас илүү хувь нь “Мэргэжилтэн санал болгосон” гэж хариулсан байна. Сургалтын төрлөөр харвал мөн л ялгаагүй “Суурь ур чадвар олгох сургалт”-д хамрагдсан иргэдийн 70.1% буюу гуравны хоёр нь “Мэргэжилтэн


санал болгосон” учир сургалтанд хамрагдсан гэсэн хариултыг өгсөн байгаа нь энэхүү сургалтанд өөрийн хүсэлтээр суралцсан иргэд ховор байгааг илтгэж байна.

Зураг 40. Хүссэн мэргэжлээрээ суралцаж чадсан эсэх, сургалтын төрлөөр /хувь/




Танхимийн болон үйлдвэрлэл дээрх сургалт болон эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалтын үйл ажиллагаа нь мэргэжил олгох хөтөлбөртэй сургалт зохион байгуулагддаг ба хүссэн мэргэжлээрээ суралцаж чадсан эсэхийг сургалтын төрлөөр харахад “Танхимийн болон үйлдвэрлэл дээрх сургалт”-т хамрагдсан иргэдийн 10.1% нь хамрагдаж чадаагүй гэсэн байгаа бол “Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт”-т хамрагдсан эмэгтэйчүүдийн 8.0% нь мөн хүссэн мэргэжлээрээ суралцаж чадаагүй гэсэн хариултыг өгсөн байна.

Зураг 41. Сургалтад хамрагдсан мэргэжлээрээ ажиллаагүй шалтгаан /хувь/




Сургалтад хамрагдсан мэргэжлээрээ ажиллаагүй иргэдийн шалтгааныг харвал 28.9% нь “Мэргэжилд тохирох ажил олдоогүй”, 50.5% нь “Бусад” гэж хариулсан байна. Бусад гэсэн хариултыг задлан авч үзвэл жирэмсэн/ хүүхэд асрах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, том хүн асардаг болон өөр мэргэжлээр ажилладаг, чадамжийн гэрчилгээ гараагүй зэрэг шалтгаанууд өндөр хувийг эзэлж байна.

Зураг 42. Сургалтын орчин /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамрагдсан иргэдийн ихэнх хувь нь сургалтын орчин болон сургалтын материал, тоног төхөөрөмжийн хүртээмжтэй, тохилог байсан гэж үзсэн байна. Сургалтаар 23.4% нь “Мэргэжлийн суурь онолын мэдлэг”, 21.6% нь “Практик ур чадвар” 15.7% нь “Хөдөлмөр эрхлэх сонирхолтой болсон” зэрэг мэдлэг ур чадваруудыг олж авсан байна.

Зураг 43. Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх, арга хэмжээгээр /хувь/



Өмнө нь төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж байсан эсэх талаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 83.8% нь хамрагдаж байгаагүй гэсэн хариултыг өгсөн байгаа бол 16.2% нь хамрагдаж байсан байна. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны төрлөөр харвал “Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт”-т хамрагдсан ахмадуудын 22.7% нь хамгийн өндөр хамрагдалттай байна.

Хүснэгт 16. Хамрагдсан төсөл хөтөлбөр, арга хэмжээ, арга хэмжээгээр

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээ	Суурь ур чадварын сургалт	Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	Залуучуудын сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт
1	Иргэн аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох	5	2	0	1
2	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1	0	0	0
3	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг	4	1	2	1
4	Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг	0	0	0	1
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	2	0	1	2
6	Суурь ур чадварын сургалт	7	0	0	4
7	Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	12	11	2	8
8	Аж ахуй эрхлэлтийн сургалт	9	1	2	1
9	Залуучуудын сургалт, зөвлөгөө	1	0	1	1

10	Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт	14	1	1	6
11	Бусад	2	0	0	0
	Нийт	57	16	9	25

Нийт 107 иргэн өмнө нь төсөл хөтөлбөр арга хэмжээнд хамрагдаж байсан байна. 2024 онд хамрагдсан сургалтын төрлөөр өмнө хамрагдаж байсан эсэх талаар харвал 7 иргэн “Суурь ур чадварын сургалт”-т, 11 иргэн “Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт”-т, 1 иргэн “Залуучуудын сургалт, зөвлөгөө”-т, 6 иргэн “Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт”-т тус тус өмнө нь хамрагдсан байсан байна.

Хүснэгт 17. Хамрагдсан он, арга хэмжээгээр

Хамрагдн он	Суурь ур чадварын сургалт	Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	Залуучуудын сургалт, зөвлөгөө	Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт
2002	2	0	0	0
2004	0	1	0	0
2007	0	1	0	0
2008	1	0	0	0
2010	0	0	0	1
2011	0	1	0	0
2012	1	0	0	0
2013	1	0	0	0
2014	0	2	0	0
2015	2	1	0	2
2016	0	2	0	1
2017	2	0	0	2
2018	5	2	1	1
2019	8	0	2	2
2020	5	0	0	0
2021	4	3	1	5
2022	13	0	1	6
2023	13	3	4	5
Нийт	57	16	9	25


Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд нэг удаа хамрагдсан иргэн дараагийн удаа 1 жилийн дараа дахин хамрагдах боломжтой байдаг. Харин 2024 онд хамрагдсан сургалтын үйл ажиллагаанд жилийн өмнө буюу 2023 онд хамрагдаж байсан эсэх талаар харвал 3 иргэн “Суурь ур чадварын сургалт”, 1 иргэн “Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт”, 2 иргэн “Эмэгтэйчүүдэд богино хугацааны ур чадвар олгох сургалт”-д тус тус хамрагдсан байна. Өмнө нь ижил сургалтандаа хамрагдсан хамрагдаагүй бүхэлд дээрх хүснэгтээр харууллаа.

Зураг 44. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авсан вэ /хувь/



Төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг 62.7% нь “Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар хэлтэс”-ээс авсан бол 24.1% нь “Цахим сүлжээ” гэж хариулжээ. Үүнээс харахад хөдөлмөр халамж, үйлчилгээний мэргэжилтнүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийн иргэдэд тодорхой хэмжээнд хангалттай хүргэдэг гэдэг нь харагдаж байна.

Зураг 45. Сургалтад хамрагдахад хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх /хувь/



Сургалтад хамрагдахад 4.2% нь хүндрэл бэрхшээлтэй байсан гэж хариулсан ба шалтгааныг нь тодруулвал хөгжлийн бэрхшээлтэй иргэн суралцах орчин муу, сургалтын газар хол, очиход хүндрэлтэй, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 46. Мэргэжилтэн холбогдсон зорилго /хувь/



Сургалтад хамрагднаас хойш мэргэжилтэн таньтай буцаж холбогдож байсан эсэх, эргэх холбоотой ажилласан эсэх талаар асуухад 23.2% нь холбогдсон гэж хариулсан байна. Ямар зорилгоор холбогдсон талаар тодруулахад мэргэжилтнүүдийн хамгийн их нь 23.0% нь “Бусад төсөл хөтөлбөр, арга хэмжээни талаарх мэдээлэл өгөх”, 22.6% нь “Хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар мэдээлэл өгөх” зорилгоор холбогдсон байна.

Регрессийн шинжилгээ

Сургалтанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлтийг сүүлийн долоо хоногт ажилласан эсэх болон сурсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэхээр хэмжих ба энэ нь судалгаанд оролцогсдын нас, хүйс, гэрлэлтийн байдал, боловсрол зэрэг нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд болон хүссэн мэргэжлээрээ сурсан эсэх, дадлага хийсэн эсэх болон сургалтын чанар зэрэг сургалттай холбоотой үзүүлэлтүүдтэй хамааралтай эсэхийг регрессийн загвараар шинжилнэ.

Сургалтын үр дүнтэй холбоотой хувьсагчид болох хөдөлмөр эрхлэлт, сурсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх гэсэн хувьсагчид бинар буюу хоёр боломжит утга авдаг тул магадлалын загвар илүү тохиромжтой. Иймд бид энэ шинжилгээнд пробит регрессийн загвар ашиглана.

Бид тэгшитгэл (1)-ын пробит загварыг үнэлснээр хөдөлмөр эрхлэх магадлал ба бусад тайлбарлагч хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээг хийх боломжтой.

$$\text{logit}(P(Y = 1)) = \ln\left(\frac{P(Y=1)}{1-P(Y=1)}\right) = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_k X_k \quad (1)$$

$P(Y = 1)$ нь хөдөлмөр эрхлэх магадлал, $\beta_0, \beta_1, \beta_2, \dots, \beta_k$ нь тайлбарлагч хувьсагчдын өмнөх коэффициентууд. $X_1, X_2, \dots, X_k$ нь тайлбарлагч хувьсагчид бөгөөд шинжилгээнд ашиглах тайлбарлагч хувьсагчид болон тэдгээрийн статистик үзүүлэлтүүдийг Хүснэгт 1-д харуулсан.

Хөдөлмөр эрхлэлт

Сургалтанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлт ба нийгэм эдийн засгийн шинж чанарын хувьсагчид болон сургалттай холбоотой хувьсагчидтай хамааралтай эсэхийг үнэлсэн пробит загварын үр дүнг Хүснэгт 2 харуулж байна. Иргэдийн хөдөлмөр эрхлэлт нь нас, боловсролын түвшин, өмнө нь сургалтанд хамрагдсан эсэхээс эерэг хамааралтай бол ам бүлийн тооноос сөрөг хамааралтай байна. Төлөвлөсөн сургалтандаа хамрагдсан эсэх, сургалтын чанарын үзүүлэлтүүд болон сургалтанд хамрагдахад хүндрэлтэй байсан эсэх нь хөдөлмөр эрхлэлттэй хамааралгүй байна.

Хүснэгт 2. Пробит загвар: Хөдөлмөр эрхлэлт

	Хөдөлмөр эрхлэлт	
	Коэффициент (1)	Маржинал нөлөө (2)
Тогтмол		
Ам бүлийн тоо	-0.105***	-0.040***
Эмэгтэй	-0.196	-0.074
Нас	0.085**	0.032**
Насны квадрат	-0.001**	0.000**
Гэрлэсэн	0.104	0.040
Бүрэн дунд	0.246	0.093
МСҮТ	0.732**	0.277**
Тусгай дунд	0.730**	0.277**
Дээд боловсрол	0.440**	0.167**
Төлөвлөсөн сургалт	0.104	0.040

Багш ур чадвартай	0.073	0.028
Анги тохитой	0.211	0.080
Тоног төхөөрөмж хүртээмжтэй	-0.032	-0.012
Өмнө нь сургалтанд хамрагдсан	0.347**	0.131**
Хамрагдахад хүндрэлтэй	0.055	0.021
Ажиглалтын тоо	612	
AIC	842.3	

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгааны өгөгдлөөс тооцоолов. * 10% ач холбогдлын түвшин, ** 5% ач холбогдлын түвшин, *** 1% ач холбогдлын түвшин.

Хүснэгт 2-ын хоёрдугаар баганад хувьсагчдын дундаж маржинал нөлөөг харуулж байна. Ам бүлийн тоо нэгээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх магадлал 0.04-өөр бага байгаа бол өмнө нь сургалтанд хамрагдсан бол хөдөлмөр эрхлэх магадлал нь 0.13-аар өндөр байна.

Мэргэжлээрээ ажиллах

Мэргэшил олгох сургалтанд хамрагдагсдын мэргэжлээрээ ажиллаж байгаа нь нийгэм эдийн засгийн шинж чанарын хувьсагчид болон сургалттай холбоотой хувьсагчидтай хамааралтай эсэхийг үнэлсэн пробит загварын үр дүнг Хүснэгт 3 харуулж байна. Сургалтанд хамрагдагсдын мэргэжлээрээ ажиллах эсэх нь гэрлэлт болон дадлага хийсэн эсэхээс эерэг хамааралтай бол ам бүлийн тооноос сөрөг хамааралтай байна. Төлөвлөсөн сургалтандаа хамрагдсан эсэх, сургалтын чанарын үзүүлэлтүүд болон сургалтанд хамрагдахад хүндрэлтэй байсан эсэх нь хөдөлмөр эрхлэлттэй хамааралгүй байна.

Хүснэгт 3. Пробит загвар: Мэргэжлээрээ ажилладаг эсэх

	Мэргэжлээрээ ажиллах	
	Коэффициент (1)	Маржинал эффект (2)
Тогтмол	-8.582	
Ам бүлийн тоо	-0.253**	-0.036**
Эмэгтэй	5.173	0.737
Нас	0.034	0.005
Насны квадрат	0.000	0.000
Гэрлэсэн	0.860*	0.123*
Бүрэн дунд	0.181	0.026
МСҮТ	-5.650	-0.805
Тусгай дунд	0.283	0.040
Дээд боловсрол	-0.106	-0.015
Төлөвлөсөн сургалт	-0.241	-0.034
Хүссэн мэргэжил	0.939	0.134
Дадлага хийсэн	0.694**	0.099**
Багш ур чадвартай	-0.258	-0.037
Анги тохитой	0.147	0.021
Тоног төхөөрөмж хүртээмжтэй	0.115	0.016
Өмнө нь сургалтанд хамрагдсан	-0.222	-0.032

Хамрагдахад хүндрэлтэй	-0.600	-0.086
Ажиглалтын тоо	265	
AIC	173.41	

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих судалгааны өгөгдлөөс тооцоолов. * 10% ач холбогдлын түвшин, ** 5% ач холбогдлын түвшин, *** 1% ач холбогдлын түвшин.

Пробит загвараас хувьсагчдын дундаж маржинал нөлөөг үнэлсэн (Хүснэгт 3-ын хоёрдугаар багана). Ам бүлийн тоо нэгээр нэмэгдэхэд мэргэжлээрээ ажиллах магадлал 0.04-өөр бага байгаа бол гэрлэсэн иргэдийн магадлал 0.12-оор өндөр, дадлага хийсэн иргэдийн мэргэжлээрээ ажиллах магадлал 0.10-аар өндөр байна.

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

6.1 Дүгнэлт

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд сургалттай харьцуулахад цөөн ам бүлтэй, орлого өндөртэй иргэд голдуу хамрагджээ. Хамрагдсан иргэдийн дийлэнх (87%) нь хөдөлмөр эрхэлж байна. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн үр дүнг хэмждэг нэг үзүүлэлт нь шинээр бий болгосон ажлын байрны тоо юм.

Дэмжлэг авсан иргэд шинээр ажлын байр бий болгох магадлал нь боловсролын түвшин, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, дэмжлэгийн өмнөх сургалтанд хамрагдсан эсэхтэй эерэг хамааралтай байна. Дэмжлэгтэй холбоотой үүссэн аливаа хүндрэл бэрхшээл ажлын байр нэмэх магадлалыг бууруулдаг байна.

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь иргэдэд орлогоо нэмэх боломж олгосноор амьжиргааны түвшинг сайжруулахыг зорьдог билээ. Иргэдийн орлого амьжиргааны баталгаажих доод түвшингээс өндөр байх магадлал нь гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, санхүүгийн дэмжлэгийн хэмжээнээс эерэг хамааралтай бол өрхийн ам бүлийн тооноос сөрөг хамааралтай байна.

Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтанд олон ам бүлтэй, орлого багатай иргэд голдуу хамрагдсан байна. Хамрагдсан иргэдийн талаас илүү нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлт нь нас, боловсролын түвшинтэй эерэг хамааралтай байна. Түүнчлэн өмнө нь сургалтанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэх магадлал өндөр байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 47% нь мэргэшил олгох сургалтанд хамрагдсан бөгөөд тэдний дөрөвний нэг орчим нь сурсан мэргэжлээрээ ажиллаж байна. Ам бүл олонтой өрхийн гишүүд сурсан мэргэжлээрээ ажиллах магадлал багатай байна. Сурсан мэргэжлээрээ ажиллахад иргэдийн гэрлэлтийн байдал болон сургалтын үеэр дадлага хийсэн эсэхээс эерэг хамааралтай байна.

6.2 Санал зөвлөмж

Ажлын байр нэмэх болон өрхийн орлого амьжиргааны баталгаажих түвшнээс өндөр байх магадлалыг пробит регрессийн загвар ашиглан шинжилсэн. Энэ шинжилгээнд санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс авсан судалгааны өгөгдлийг ашиглалаа. Энэхүү шинжилгээ нь хамааран хувьсагч болон тайлбарлагч хувьсагчдын хооронд ямар нэг корреляци хамаарал байгаа эсэхийг л харуулж байгаа бөгөөд шалтгаант хамаарлыг харуулж чадахгүй юм. Цаашид санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь ажлын байр нэмэгдүүлж байгаа эсэх болон иргэдийн амьжиргааг дээшлүүлж байгаа эсэхийг нөлөөллийн үнэлгээний арга зүй ашиглан нарийн хэмжих шаардлагатай.

Сургалтанд хамрагдсан иргэд хөдөлмөр эрхлэх болон мэргэжлээрээ ажиллах магадлалыг пробит регрессийн загвар ашиглан шинжилсэн. Энэ шинжилгээнд сургалтанд хамрагдсан иргэдээс авсан судалгааны өгөгдлийг ашиглалаа. Энэхүү шинжилгээ нь хамааран хувьсагч болон тайлбарлагч хувьсагчдын хооронд ямар нэг корреляци хамаарал байгаа эсэхийг л харуулж байгаа бөгөөд шалтгаант хамаарлыг харуулж чадахгүй юм. Цаашид сургалтын үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж байгаа эсэх болон иргэдийн цалингийн орлогыг өсгөдөг эсэхийг нөлөөллийн үнэлгээний арга зүй ашиглан нарийн хэмжих шаардлагатай.